


16. Суралцагчийн санхүү нэгтгэл

Тус модулийн зорилго нь ДБУМС-д суралцагчийн санхүүг бүртгэж удирдах, нийт төлбөр төлсөн оюутны тоо болон буцалтгүй тусламж, тухайн сургуулийн зардлаар суралцдаг, хувийн зардлаар суралцдаг, бусад зардлаар суралцдаг гэх мэт төлбөр төлөлтийн олон хэлбэрээр тайлан мэдээ авах боломжтой болох төдийгүй сургалтын байгууллагын хичээлийн жилийн дундаж төлбөрийн мэдээг авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг боломж бүрдэх юм.



Суралцагчийн санхүүгийн бүртгэлийн мэдээлэл

№	Талбар	Тайлбар	Жишээ
1.	Суралцагч	Регистрийн дугаарын мэдээллийг оруулах үед УБЕГ-ын иргэний мэдээллийн сангаас регистрийн дугаараар шалган суралцагчийн эцэг, эхийн нэрийн мэдээллийн татан харуулна.	AA11223344
2.	Сургалтын байгууллагын нэр	Суралцагчийн харъяалагдах сургалтын байгууллагын нэрийг харуулна.	МУИС
3.	Салбар, бүрэлдэхүүн сургуулийн нэр	Суралцагчийн суралцаж буй салбар, бүрэлдэхүүн сургуулийн нэрийг харуулна.	Хууль зүйн сургууль
4.	Боловсролын түвшин	Суралцагчийн суралцаж буй боловсролын түвшин (1. Дипломын боловсрол, 2. Бакалаврын боловсрол, 3. Докторын	Бакалавр

		боловсрол) -г харуулна..	
5.	Мэргэжлийн чиглэл	Суралцагчийн суралцаж буй хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, индексийг харуулна.	Эрх зүй
6.	Сургалтын хөтөлбөр	Суралцагчийн суралцаж буй сургалтын хөтөлбөрийг харуулна.	Эрх зүй
7.	Сургалтын төлөвлөгөө	Суралцагчийн суралцаж буй сургалтын төлөвлөгөөг харуулна.	Эрх зүй
8.	Сургалтын хэлбэр	Суралцагчийн суралцаж буй хөтөлбөрийн сургалтын хэлбэр (1.Өдөр, 2. Орой 3. Эчнээ)-г харуулна.	Өдөр
9.	Суралцагчийн түвшин	Хэрэв суралцагчийн суралцаж буй сургалтын хөтөлбөр үе шаттай бол суралцагчийн курс, дамжааны төрөл (1-р дамжаа, 2-р дамжаа, 3-р дамжаа, 4-р дамжаа, 5-р дамжаа, 6-р дамжаа) -ийг харуулна.	1-р дамжаа
10.	Суралцагчийн төлөв	Суралцагчийн суралцаж байгаа эсэх төлөвийг харуулна.	Суралцаж байгаа
11.	Хичээлийн жил	Суралцагчийн төлбөр төлөх хичээлийн жилийг сонгоно.	2019-2020 оны хичээлийн жил
12.	Хичээлийн улирал	Суралцагчийн төлбөр төлөх хичээлийн улиралыг сонгоно.	1-р улирал
13.	Нийт төлөх дүн	Суралцагчийн хичээлийн жилд төлөх төлбөрийн нийт дүнг оруулна.	8,000,000
14.	Нийт төлөх алданги / торгууль	Суралцагчийн төлөх алданги, торгуулийн дүнг оруулна.	-
15.	Төлбөрийн хэлбэр	Суралцагчийн төлбөр төлж буй төлбөрийн хэлбэрийг сонгоно.	Хувийн зардлаар
16.	Төлсөн огноо	Төлбөр төлсөн огноог оруулна.	2019/09/15
17.	Төлсөн дүн	Төлсөн төлбөрийн дүнг оруулна.	4,000,000
18.	Алданги / торгуулийн дүн	Төлсөн алданги, торгуулийн дүнг оруулна.	-
19.	Тайлбар	Нэмэлт дэлгэрэнгүй тайлбар мэдээллийг оруулна.	-